

ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХАД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд /цаашид төсвийн байгууллага гэх /-ийн батлагдсан жилийн төсөв, түүний гүйцэтгэлийг /цаашид мэдээлэл гэх/ олон нийтэд мэдээлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэ журамд заасан төсөв, санхүүгийн ил тод байдалтай холбогдсон зохицуулалт нь хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамаарах төсөвт болон хууль тогтоомжийн дагуу улсын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилд хамаарахгүй.

**Хоёр. Төсөв, санхүүгийн мэдээллийг олон нийтэд түгээхэд
баримтлах зарчим**

- 2.1. Мэдээлэл нь иргэд, олон нийтэд нээлттэй байх бүхий л боломж, арга хэрэгсэлээр хангагдсан байх;
- 2.2. Төсвийн байгууллага мэдээллийг олон нийтэд тогтмол хугацаанд, тогтоосон стандартын дагуу үнэн зөв, ил тод байдлаар хүргэх;
- 2.3. Мэдээлэл нь тухайн жилийн батлагдсан төсөв болон Төсвийн тухай хуульд нийцсэн байх.

**Гурав. Мэдээллийн ангилал, бүтэц, мэдээлэл боловсруулахад
тавигдах шаардлага**

- 3.1 Төсвийн байгууллагын мэдээлэл дараах бүтэцтэй байна:
 - 3.1.1 эрх бүхий байгууллагаас батласан жилийн төсөв;
 - 3.1.2 дунд хугацааны бодлого, зорилт, стратеги;
 - 3.1.3 үзүүлэх үйлчилгээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт;
 - 3.1.4 төсвийн гүйцэтгэл, аудитын дүгнэлт.
- 3.2 Энэ журмын 3.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна :
 - 3.2.1 эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсвийг хүрэх үр дүн, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтээр;
 - 3.2.2 орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/;
 - 3.2.3 урсгал зардал /үндсэн цалин, цалингийн нэмэгдэл, бараа үйлчилгээний зардал, татаас, шилжүүлэг/;
 - 3.2.4 хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессийн зүйлсийн жагсаалт
 - 3.2.5 улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа
 - 3.2.6 зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого/;
 - 3.2.7 байгууллагын батлагдсан орон тоо,
- 3.3 Энэ журмын 3.1.2-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:
 - 3.3.1 байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэг;
 - 3.3.2 дунд хугацааны зорилго, зорилт, зорилтыг хэрэгжүүлэх стратеги;

- 3.3.3 зорилтын хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт;
- 3.4 Энэ журмын 3.1.3-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:
- 3.4.1 байгууллагын чиг үүргийн дагуу иргэдэд үзүүлэх үйлчилгээ, түүний төрөл;
- 3.4.2 нэгж үйлчилгээний өртөг, зардал;
- 3.4.3 үйлчилгээний стандарт;
- 3.5 Энэ журмын 3.1.4-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:
- 3.5.1 төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ журмын 4.3-д заасан хугацааны дотор 3.2-т тодорхойлсон үзүүлэлтүүдээр, хүрсэн үр дүнг 3.3.3, 3.4.3-т заасан шалгуур үзүүлэлтээр;
- 3.5.2 төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан байдлаар;
- 3.5.3 төсөв хэмнэгдсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан байх;
- 3.5.4 төсвийн хэмнэлтийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх
- 3.5.5 хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт;
- 3.5.6 хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын мэдээлэл (шалгарсан аж ахуй нэгж, тоо хэмжээ, үнэ)
- 3.5.7 төсвийн хагас бүтэн жилийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, тухайн тайланд тусгагдсан асуудлуудын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дөрөв. Мэдээллийг олон нийтэд хүргэх хугацаа, давтамж

- 4.1.Төсөв, санхүүгийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэхдээ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9.1, Төсвийн тухай хуулийн 8.8-8.10-д нийцүүлж энэ журмын 4.2, 4.3-д заасны дагуу мэдээлнэ.
- 4.2.Тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталж, хүчин төгөлдөр болсны дараа төсвийн захирагч дор дурдсан хугацаанд олон нийтэд мэдээлнэ:
- 4.2.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын төсөв, Хүний хөгжил сан, Нийгмийн даатгалын сангийн төсвийг ажлын 3 хоногийн дотор;
- 4.2.2. төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн багцын төсвийг 7 хоногийн дотор
- 4.2.3. төсвийн байгууллага өөрийн төсвөө 10 хоногийн дотор.
- 4.3.Төсвийн гүйцэтгэлийн тайланг эрх бүхий этгээд дор дурьдсан хугацаанд олон нийтэд мэдээлнэ:
- 4.3.1. төсвийн байгууллага, хуулийн этгээд сар, улирлын тайланг сар, улирлын гүйцэтгэл гарснаас хойш 7 хоногийн дотор;
- 4.3.2. төсвийн байгууллага, хуулийн этгээд хагас жилийн тайланг 7 сарын 15-ны дотор, жилийн тайланг 2 дугаар сарын 25 ны дотор;
- 4.3.3. төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг 4 дүгээр сарын 25-ны дотор;
- 4.3.4. сум, дүүргийн төрийн сан хагас жилийн тайланг 7 дугаар сарын 25-ны дотор, жилийн тайланг 3 дугаар сарын 5-ны дотор;
- 4.4. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын дүгнэлт гарсанаас хойш 7 хоногийн дотор;
- 4.5. төсвийн байгууллага, хуулийн этгээд өмнөх оны санхүүгийн тайланд нь хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор.

Тав. Мэдээллийг олон нийтэд хүргэх

- 5.1. Төсвийн байгууллага мэдээллийг олон нийтэд хүргэхдээ мэдээллийн самбар, цахим болон хэвлэмэл хуудас, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглана.
- 5.2. Цахим хуудас болон мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран төсвийн байгууллага мэдээллийн самбарыг заавал ажиллуулна.

- 5.3. Журмын 5.2-т заасан мэдээллийн самбарын өргөн болон урт нь 1.5 метрээс багагүй хэмжээтэй байна. Мэдээллийн самбар нь байгууллагын гол хаалганы хажууд эсхүл хаалганы урдаас харсан хананд байрлаж, мэдээллийг шинэчлэх боломжтой байдлаар хийгдсэн байна. Самбарт тавигдах мэдээллийг журмын 4.2-4.3-т заасан хугацаанд тогтмол шинэчилж байна.
- 5.4. Мэдээллийн самбарт байршуулсан мэдээллийг дэлгэрүүлж авах тохиолдолд тэрхүү мэдээллийг хэрэглэгч ямар эх сурвалжаас олж авахыг тодорхой заасан байна.
- 5.5. Мэдээллийн самбарт байршуулсан мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулж байгууллагын дарга болон мэдээллийг бэлтгэсэн ажилтан гарын үсэг зурсан байна.
- 5.6. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн самбарт байрлуулах энэ журмын 3.2-3.5-д заасан шаардлагыг хангах мэдээллийн бүтэц, агуулга, жишиг маягт зэргийг агуулсан үлгэрчилсэн заавар, зөвлөмжийг өөрийн албан ёсны цахим хуудас (www.mof.gov.mn) болон төсвийн ил тод байдлын цахим хуудас (www.iltod.gov.mn)-нд байршуулна.
- 5.7. Байгууллага олон нийтэд хүргэх мэдээллийг бэлтгэхдээ энэ журмын 5.6-т заасан зөвлөмжийг баримтлана.
- 5.8. Төсвийн байгууллага, хуулийн этгээд цахим хуудастай тохиолдолд тухайн цахим хуудас нь “байгууллагын төсөв” гэсэн цэстэй байна. Энэхүү цэсэнд журмын 3.1-3.5-д заасан мэдээллүүдийг байрлуулж, журмын 4.2-4.3-т заасан хугацааны дагуу тогтмол шинэчилж байна.

Зургаа. Журмын хэрэгжилтийг хангах

6.1. Төсвийн захирагч энэхүү журамд заасан мэдээллийг тогтмол шинэчлэн журмын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

6.2. Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг олон нийтэд хэрхэн хүргэж ажилласан талаарх тайланг жилийн төсвийн төслийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

6.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх ажлын биелэлтийг жилийн эцсийн байдлаар гарган Засгийн газарт танилцуулж, биелэлтийг өөрийн цахим хуудсаар мэдээлнэ.

Долоо. Хариуцлага

7.1. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---000---